

ДОРНОД АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС
/Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 2025 оны эхний хагас/

2025 он

**ДОРНОД АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	2025 онд хүрэх зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэтгэлийн хувь
1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилго 1: Даатгуулагчийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн цахим тогтолцоог бэхжүүлнэ.							
1.2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.2-т заасан Тооцоолол, нотолгоот дүн шинжилгээ, судалгаанд тулгуурласан төлөвлөлтийг хэрэгжүүлж, даатгуулагчийн эрэлт хэрэгцээг хангана.							
1.2.1	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтад хийгдсэн дүн шинжилгээний мөрөөр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ..	-	Дүн шинжилгээний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, хэрэгжилтийн хувь	5 удаагийн зөвлөгөө өгөх сургалт зохион байгуулсан.	Цахим өгөгдөлд хийсэн дүн шинжилгээнд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.	2024 оны 7-12 дугаар сарын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтын үр дүнд дүн шинжилгээ хийж, нийтлэг гарч буй алдаа зөрчилд лавлагаа шатлалын 3, анхан шатны 16 эрүүл мэндийн байгууллагуудад тусламж, үйлчилгээний чанар сайжруулах зөвлөмж тус тус хүргүүлэн ажилласан.	80
1.2.2	Эрүүл мэндийн даатгалын 2022, 2023, 2024 оны үйл ажиллагааны тайлан, статистик мэдээллийн эмхэтгэлийг гэрээт эрүүл мэндийн байгууллага болон олон нийтэд түгээн сурталчилна.	-	Мэдээллээр хангасан ЭМБ, иргэдийн тоо	-	Статистик мэдээллийг олон нийтэд түгээн сурталчилах арга хэмжээг зохион байгуулсан байна.	Эрүүл мэндийн даатгалын байгууллагаас хийж хэрэгжүүлж буй ажил үйлчилгээ, гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагуудын мэдээлэл, эрүүл мэндийн даатгалын байгууллагаас худалдан авч буй тусламж, үйлчилгээ болон гэрээ бүхий ЭМБ-дад олгосон санхүүжилт цаг үетэй холбоотой мэдээ, мэдээллийг хэлтсийн фэйсбүүк хаяг, фэйж хуудсаар дамжуулан хүргэхээс гадна мэдээ, мэдээллийн самбарт байршуулан олон нийтэд хүргэж байна. 2022-2024 оны статистик эмхэтгэл одоогоор ирээгүй байна.	90
1.2.3	“Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” ЭМДҮЗ-ийн	-	Журмыг хүргүүлж танилцуулсан	ЭМДҮЗ-ийн 2024 оны 06, 14 дүгээр тогтоолыг	Журмыг хэрэгжүүлсэн байна.	ЭМДҮЗ-ийн 2025 оны “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 03, 04 дүгээр тогтоол, ЭМДЕГ-ын даргын	100

	тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллана.		ЭМБ-ын тоо - Хяналт тавьж ажилласан ЭМБ-ын тоо	гэрээт 18 эрүүл мэндийн байгууллагад танилцуула, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.		2025 оны "Журам шинэчлэн батлах тухай" А/30 тушаалыг гэрээ бүхий 18 эрүүл мэндийн байгууллагад тус тус хүргүүлэн танилцуулж, зөвөлгөө, мэдээллээр ханган, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.	
1.2.4	"ЭМДС-аас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээнд өөрчлөлт оруулах" тухай ЭМДҮЗ-ийн шинэчлэн батлагдсан тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэнд хяналт тавин ажиллана.	-	Журмыг хүргүүлж танилцуулсан ЭМБ-ын тоо, хяналт тавин ажилласан ЭМБ тоо	ЭМДҮЗ-ийн 2024 оны 05 дугаар тогтоолыг гэрээ бүхий анхан шатны 16 эрүүл мэндийн байгууллагын эмч нарт цахимаар 2, танхимаар 1 удаа мэдээлэл өгч, мэргэжил арга зүйгээр ханган ажилласан. Хамрагдсан эмч, ажилчдын тоо 40	Шинэчлэгдсэн журмыг ЭМБ-дад танилцуулж, хяналт тавин ажиллаж хэрэгжилтийг тайлагнасан байна.	Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах "Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээнд өөрчлөлт оруулах тухай" ЭМДҮЗ-ийн 2025 оны 03, дугаар тогтоолыг гэрээ бүхий анхан шатны 16 эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдэд танхимаар 1, цахимаар 2 удаа танилцуулах мэдээлэл хүргэж, мэргэжил арга зүйгээр ханган ажилласан. Хамрагдсан эмч, мэргэжилтнүүдийн тоо-36	100
1.2.5	Даатгуулагчийг эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээнд хамруулсан эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний гүйцэтгэл чанар, төлбөрийн хяналтыг хэрэгжүүлж	-	Санхүүжүүлсэн мөнгөн дүн Хамрагдсан даатгуулагчийн тоо	2024 онд 7372 даатгуулагч эрт илрүүлэх үзлэгт хамрагдсан байна. 990.2 сая төгрөгийн санхүүжилт	Эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээ хийж, гүйцэтгэл ирүүлсэн ЭМБ-уудын гүйцэтгэлд хяналт хийж, санхүүжилтийг	Энэ оны 1-4 дүгээр сард аймгийн хэмжээнд эрт илрүүлэх оношилгоо, шинжилгээнд нийт 1827 даатгуулагчийг хамруулж 327.3 сая төгрөгний зардлын төлбөр нэхэмжилсэнээс 1611 тохиолдлын 318.8 сая төгрөгийн гүйцэтгэлийг олгохоор баталгаажуулж, 216	100

	ажиллана.			олгосон.		тохиолдлын 8.4 сая төгрөгний зөрчлийг цахимын хяналтаар илрүүлэн хасч тооцсон байна. Зөрчлийн шалтгаан тайлбарыг БОЭТ-ийн холбогдох мэргэжилтэнд тухай бүр хүргүүлэв. Эрүүл мэндийн сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын хамтарсан 2024 оны А/413, А/151 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд аймгийн ЭМГ-тай хамтран өрх, сумын эрүүл мэндийн төвийн дарга, шүдний эмнэлгийн төлөөллүүдэд мэдээлэл хүргэж ажилласан.	
1.2.6	ЭМД-ын тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд хагас жил тутам дүн шинжилгээ хийх, гүйцэтгэлд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээний санал боловсруулж, Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлнэ.	-	Хийсэн дүн шинжилгээний тоо, Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн саналын тоо	Анхан шатны ЭМБ-ын Нэхэмжлэлийн хяналтын тогтоолын төсөлд санал хүргүүлсэн.	Хагас жил тутам дүн шинжилгээ хийж, санал боловсруулан Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлсэн байна.	ЭМД-ын тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд хагас жил тутам дүн шинжилгээ хийх, гүйцэтгэлд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээнд одоогоор санал боловсруулаагүй болно.	80
1.2.7	“ЭМДС-аас эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээ”-ний жагсаалтыг шинэчлэн баталсан ЭМДҮЗ-ийн тогтоолыг гэрээт ЭМБ-д хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллана	-	Журмыг хүргүүлж танилцуулсан ЭМБ-ын тоо, хяналт тавьж ажилласан ЭМБ-ын тоо	Хяналт тавьж ажилласан эмийн сангийн тоо 37	Шинэчлэгдсэн журмыг ЭМБ-дад танилцуулж, хяналт тавин ажиллаж хэрэгжилтийг холбогдох нэгжид тайлагнасан байна.	ЭМДС-аас эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээ”-ний жагсаалт ЭМДҮЗ-ийн 2022 оны 11 дүгээр тогтоолын хүрээнд Новартис эмийн жагсаалтад байсан зарим нэр төрлийн эмийг тогтоолын хүрээнд буцаан хөнгөлөлттэй олгох талаар гэрээ бүхий 37 эмийн санд мэдээлсэн.	100
1.2.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.4-т заасан “Салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгоно” зорилтын хүрээнд:							
1.4.1	Байгууллагын 2023-2026	-		ЭМДҮЗ-ийн	Эрх зүйн баримт	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий	100

	оны СТ 2.1.3, БГТ-1.4.3 Салбарын хууль тогтоомж, гэрээ, санамж бичиг, эрх зүйн актын төсөлд санал өгнө.		Хүргүүлсэн саналын тоо	тогтоолын шинэчлэлд 2 удаа, ЭМС-ын 2019 оны А/611 дүгээр тушаалын шинэчлэлийн төсөлд 1 удаа санал хүргүүлсэн байна.	бичигт холбогдох саналыг боловсруулж хүргүүлсэн байна.	газрын даргын 2022 оны А/139-р тушаалын өөрчлөлтөд санал -8 ЭМД-ын орлого бүрдүүлэх, цуглуулах, төвлөрүүлэх журмын төсөлд санал-5 Эд эс, эрхтэн шилжүүлэх хуулийн төсөл, Улсын байцаагчийн мэргэшлийн зэрэг тогтоох, зэргийн нэмэгдэл олгох журмын төсөлд саналуудыг тус тус хүргүүлж ажиллав.	
1.4.2	Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, Прокурорын байгууллагатай хамтран ажиллана.	-	Зөрчлийн хэргийн тоо Санд төвлөрүүлсэн мөнгөн дүн	2024 он, аймгийн Прокурорын байгууллагатай хамтран гэм хэрэгт холбогдсон 18 иргэний судалгааг гарган, сан төвлөрүүлсэн мөнгөн дүн 54. сая төгрөг	Зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд явуулсан байна.	- Зөрчлийн хэргийн тоо-62 - Лавлагаа мэдээлэлд хамрагдсан иргэдийн тоо-62, - Нийт нэхэмжилсэн мөнгөн дүн 58.4 сая төгрөг, - Санд төвлөрүүлсэн мөнгөн дүн 32.7 сая төгрөг байна. Гэмт хэрэг зөрчлийн улмаас хохирсон даатгуулагчийн лавлагаа мэдээллийг Цагдаагийн газарт 61, Прокурорын газарт 1, удаа тус тус гаргаж хүргүүлсэн.	80
2.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилго 2: Эрүүл мэндийн даатгалын хамралт, орлогыг нэмэгдүүлж, үзүүлэх тусламж, үйлчилгээний тоо хэмжээ, хүрээг өргөтгөнө.							
2.1.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилго 2: “Эрүүл мэндийн даатгалын хамралт, орлого, тусламж, үйлчилгээний тоо хэмжээг нэмэгдүүлнэ” зорилтын хүрээнд:							
2.1.1	ЭМДТХ-9.1.9, “Алсын хараа 2050” МУУХХБ-2.2.19, БСТ-2.1.1, 2.1.2, МУХТЖҮЧ-2.2.5, МУЗГҮАХ 2.1.7, БГТ 2.1.1	-	Малчдын эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь	2024 оны хамрагдалтын хувь 52	2025 онд 60 хувиас дээш хамруулна	2025 онд нийт хамрагдвал зохих малчны тоо-3499, үүнээс тайлант хугацаанд хамрагдвал зохих 1160, хамрагдсан малчны тоо-814 хамрагдалтын хувь 70 байна.	70
	Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлөх иргэдийн шимтгэл төлөлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.		Оюутны эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын	2024 оны хамрагдалтын хувь 142	2025 онд 90 хувиас доошгүй хамруулна.	2025 онд нийт хамрагдвал зохих оюутны тоо-817, үүнээс тайлант хугацаанд хамрагдвал зохих 272, хамрагдсан 966 хамрагдалтын хувь	360

		хувь			360 байна.	
		Тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй иргэдийн ЭМДаатгалд хамрагдалтын хувь	2024 оны хамрагдалтын хувь 67	2025 онд 80 хувиас дээш хамруулна	2025 онд нийт хамрагдвал зохих тодорхой хөдөлмөр эрхлээгүй иргэдийн тоо-4497, үүнээс тайлант хугацаанд хамрагдвал зохих 1499, хамрагдсан-980 хамрагдалтын хувь 64 байна. Энэ онд Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлөх иргэд нийт 8830 байна. Тайлант хугацаанд 2943 иргэн хамруулахаас хамрагдсан 2758. /гадаадын иргэн-17 хамруулахаас хамрагдсан 8/ хамрагдалтын хувь 94 байна.	64
		Байгууллага, аж ахуйн нэгжийн хувь	2024 оны хамрагдалтын хувь 90	2025 онд 90 хувиас дээш хамруулна	2025 онд аж, ахун нэгж байгууллагын ажилтан 13134 хамруулахаас 12387 хамрагдсан. Хамрагдалт хувь 94.3 байна.	94.3
2.1.2	Сангийн зарлагын төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж тайлан, мэдээг гарган холбогдох нэгжид хүргүүлнэ.	Нэгтгэн хүргүүлсэн тайлангийн тоо	2024 онд сангийн зарлагын тайлан ЭМДЕГ-т 4 удаа, санхүүжилтийн мэдээг АЗДТГ, ЭМГ-т тус бүр 2 удаа, цаг үетэй холбоотой мэдээ 12 удаа хүргүүлсэн.	Тайлан, мэдээг хугацаанд нь, үнэн зөв гарган хүргүүлсэн байна.	Сангийн зарлагын төсвийн гүйцэтгэлд хяналт тавин, ажиллаж байна. - 2025 оны 1-5 дугаар сарын ШШГГ-т хорих ял эдэлж буй 13 ялтаны төр хариуцахын ногдуулалтын мэдээг СБХ-т - 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад олгосон санхүүжилтийн мэдээг аймгийн ЗДТГ, ЭМГ-т - Гэрээт эрүүл мэндийн байгууллагын 1-3 дугаар сарын тусламж үйлчилгээний зардлын бүртгэлийг ЭМГ-т 3 удаа тус тус хүргүүлэн ажилласан.	100
2.1.3	ЭМДТХ-9.1.9, "Алсын хараа 2050" МУУХХБ-2.2.19, БСТ-2.1.1, 2.1.2, МУХТЖҮЧ-2.2.5,	Төвлөрүүлсэн мөнгөн дүн	2024 онд орлогын төлөвлөгөөний биелэлт 98.8	ЭМД-ын орлогын төлөвлөгөөн	2025 оны 1-4 дүгээр сарын өссөн дүнгээр ажил олгогч даатгуулагчийн шимтгэлийн орлого 4,388,704.2	100

	МУЗГҮАХ 2.1.7, Эрүүл мэндийн даатгалын төсвийн сангийн орлогын төлөвлөгөөний биелэлт зардлын гүйцэтгэлийг хангуулж, тайлагнана.			хувьтай	ий биелэлтийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.	мянган төгрөг, шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг даатгуулагчийн шимтгэлийн орлого 379,054.0 мянган төгрөг буюу 4,767,758.2 мянган төгрөгийн орлого төвлөрсөн байна.	
2.2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.2-т заасан “Даатгалын сангийн тогтвортой байдлыг хангаж, эрсдэлээс хамгаална” зорилтын хүрээнд:							
2.2.1	Байгууллагын 2023-2026 оны СТ-ний 2.2.1, БГТ-2.2.1 Өглөг, авлага үүсгэхгүй ажиллана. Авлага барагдуулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авна.	- ЭМДС	Өглөг, авлагын тоо хэмжээ, тайлан	2024 онд 715.3 сая төгрөгийн өглөгтэй, тайланг ЭМДЕГ-т хүргүүлсэн.	Өглөг, авлага барагдуулах чиглэлээр арга хэмжээ авч ажилласан байна	Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудаас тухайн сард үзүүлсэн тусламж үйлчилгээний зардлын гүйцэтгэлийн нэхэмжлэл, албан тоотыг dornod_invoice@emd.gov.mn хаягаар тогтсон хугацаанд, тогтмол хүлээн авч, Outlook програмд архив үүсгэн хадгалах, health.gov.mn болон санхүүгийн Fiscus програмын дүнтэй тулган өглөг, авлагыг хянан ажиллаж байна. Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад 2.2 тэрбум төгрөгийн өглөгтэй байна.	100
3. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилго3: Тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, худалдан авах үйл ажиллагааг хялбарчилна							
3.1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.1-т заасан “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчийн чанарт үндэслэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авч, чанарын хяналтыг сайжруулна” зорилтын хүрээнд:							
3.1.1	Байгууллагын 2023-2026 оны СТ-ний 3.1.2, БГТ 3.1.1 Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага, өрх, сум тосгоны эрүүл мэндийн төв, эмийн сангуудын 2024 оны гэрээг дүгнэх ажлыг зохион байгуулна.	-	Гэрээ дүгнүүлсэн эрүүл мэндийн байгууллагын тоо	2024 онд лавлагаа 5, өрх 3, СЭМТ-13 нийт 21 гэрээт ЭМБ дүгнэгдсэн.	Гэрээт ЭМБ-уудын гэрээг хугацаанд нь дүгнэж, холбогдох арга хэмжээний саналыг Худалдан авалт гэрээлэлтийн газарт хүргүүлсэн байна.	2024 онд ЭМДЕГ-тай гэрээ бүхий нийт 58 эрүүл мэндийн байгууллагуудын эрүүл мэндийн тусламж үйлчилгээг худалдан авах, эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх гэрээг дүгнэв. Үүнд: Лавлагаа шатлалын-5 Анхан шатны-16 /Өрх 3, СЭМТ 13/ Эмийн сан-37 байна. Гэрээ дүгнэсэн байдлыг ерөнхийд нь авч үзвэл: Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагыг 3 үзүүлэлтээр дүгнэн	100

						<p>гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт дээр зохих оноог авч, нэхэмжлэлийн зөрчилтэй байдал нийт нэхэмжлэлийн 4 хувьд нь зөрчил илэрсэн, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэн хангалттай үнэлэгдсэн.</p> <p>Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын үнэлгээг авч үзвэл:</p> <ul style="list-style-type: none"> - Маш сайн -6 - Хангалттай -9 - Хангалтгүй-1 байна. <p>Мөн Эмийн сангуудын гэрээний хэрэгжилтийг үнэлэхэд:</p> <ul style="list-style-type: none"> - 90-ээс дээш оноогоор үнэлэгдсэн 28 байна. Эдгээр эмийн сангуудтай гэрээг үргэлжлүүлэн байгуулсан байна. - 80-89.9 хүртэлх оноогоор үнэлэгдсэн 8 эмийн санд хугацаатай зөвлөмж хүргүүлэн, биелэлтэд хяналт тавьж гэрээг үргэлжлүүлэн байгуулсан. - 60-79.9 оноогоор 1 эмийн сан үнэлэгдсэн. Хангалтгүй үнэлэгдсэн эмийн санд Улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлэн гэрээг цуцлах арга хэмжээ авсан болно. <p>Мөн Хангалтгүй үнэлэгдсэн Цагаан-Овоо сумн эрүүл мэндийн төвд улсын байцаагчийн зөвлөмжийг хүргүүлэн, хяналт тавин ажиллаж байна. Гэрээ дүгнэх явцад эрүүл мэндийн төвүүдээс ирүүлсэн санал, хүсэлтийг илтгэх хуудсаар уламжилсан болно.</p>
		-	Гэрээний	2024 онд	Гэрээний	2024 онд лавлагаа шатлал гэрээний

			хэрэгжилтийн хувь	лавлагаа шатлал гэрээний хэрэгжилтийн хувь 87 Анхан шат гэрээний хэрэгжилт хувь 89	хэрэгжилтийн хувиас 90 доошгүй байна.	хэрэгжилтийн хувь 87 Анхан шат гэрээний хэрэгжилт хувь 89 Эмийн сангуудын гэрээний хэрэгжилт 91.9 хувьтай тус тус үнэлэгдсэн байна.	
3.1.2	2025 онд Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах гэрээ, даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх, гэрээг холбогдох ЭМБ-тай байгуулах үйл ажилагааг зохион байгуулана.	-	Шинэчлэн байгуулсан гэрээний тоо	Эмийн сан 37	Гэрээний дүгнэлтээр хангалттай үнэлэгдсэн, шинээр хүсэлт ирүүлсэн эмийн сангуудтай гэрээ байгуулсан байна.	Энэ онд “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ худалдан авах гэрээ”-г 21, “Даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх гэрээ”-г -Хангалттай үнэлэгдсэн 36 -Шинээр хүсэлт ирүүлсэн 1 Нийт 37 эмийн сантай байгуулан ажиллаж байна.	100
3.1.3	Чанар, төлбөрийн хяналтын журамд орсон өөрчлөлтийн талаар гэрээт эрүүл мэндийн байгууллагуудыг мэдээллээр хангаж, хэрэгжилтийг ханган ажиллана.	-	Мэдээллээр хангасан ЭМБ-ын тоо	Гэрээ бүхий 21 ЭМБ-ыг мэдээллээр хангаж хэрэгжилтийг тайлагнасан.	Журамд орсон өөрчлөлтийг ЭМБ-дад танилцуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж тайлагнасан байна.	ЭМДЕГ-ын даргын 2025 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/30 тушаал Нэхэмжлэлийг хянах журмыг гэрээт 18 эрүүл мэндийн байгууллагад хүргүүлэн танилцуулсан. Чанар, төлбөрийн хяналтын журмын өөрчлөлтөд тусгуулах саналаа хүргүүлэх талаар эрүүл мэндийн байгууллагуудад зөвлөсөн.	100
3.2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.2-т заасан “Даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарт холбогдох стандарт, эмнэлзүйн удирдамж, журмын дагуу хяналт тавьж, тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулна” зорилтын хүрээнд:							
3.2.1	БГТ 3.2.1 Олон улсын эмнэлзүйн удирдамжид суурилсан шалгуурыг үндэслэн гэрээт эрүүл мэндийн байгууллагуудад нэхэмжлэлийн хяналтыг	ЭМ ДС	Гүйцэтгэл ирүүлсэн ЭМБ-ын тоо, нэхэмжилсэн даатгуулагчийн тоо, мөнгөн дүн,	Нийт 21 ЭМБ-д 31.3 тэрбум төгрөгийн гүйцэтгэлд нэхэмжлэлийн хяналт хэрэгжүүлсэн.	Хуваарьлагдсан түүвэрт нэхэмжлэлийн нарийвчилсан хяналтыг журмын дагуу хугацаанд нь хийж хэрэгжүүлсэн	Энэ оны 1-3 дугаар сарын байдлаар гэрээ бүхий лавлагаа шатлалын 5 эрүүл мэндийн байгууллагын гүйцэтгэлд нийт 77671 тохиолдлын 8,498,427.2 мянган төгрөг нэхэмжилсэнээс 76855 тохиолдлын 8,181,271.2 мянган төгрөгийг олгохоор тооцсон. Мөн хэлтсийн нийт байцаагч	100

	хэрэгжүүлнэ.				байна.	ажилтнуудад хуваарьлагдсан 5820 түүвэрт нэхэмжлэлийн хяналтыг хэрэгжүүлэн шалгуурын дагуу үнэлэхэд 999 тохиолдлын 103.4 сая төгрөгийн зөрчлийг илрүүлэн хасч тооцсон байна. Гэрээ бүхий 16 (анхан шатны) эрүүл мэндийн байгууллагуудаас 2025 оны 1-3 дугаар сард нийт 18637 тохиолдлын 1,256,747.8 мянган төгрөгний гүйцэтгэл бүхий нэхэмжлэлийг хүлээн авч хяналтыг хэрэгжүүлэн 18380 тохиолдлын 1,222,167.7 мянган төгрөгний санхүүжилтийг олгохоор тооцож, (шалгуур хангаагүй, анхан шатны баримт ирүүлээгүй, код ахиулсан давхардуулж нэхэмжилсэн, чанаргүй үзүүлсэн тусламж үйлчилгээ үзүүлсэн) 257 тохиолдлын 34,580.1 мянган төгрөгний зөрчлийг эмч, байцаагчийн хяналтаар илрүүлэн хасч баталгаажуулан, илэрсэн зөрчилд тайлбар жагсаалтыг давхардсан тоогоор нийт 16 эрүүл мэндийн байгууллагад 15 албан тоот төлөвлөн хавсралтаар хүргүүлсэн байна.	
3.2.2	БГТ 3.2.3 Гэрээт эрүүл мэндийн байгууллагад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ.	-	Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн байгууллагын тоо	2024 онд 23 ЭМБ-д зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн.	Эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн байна.	Аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг гэрээ бүхий 22 эмийн санд Засгийн газраас хэрэгжүүлж буй эрүүл мэндийн салбарын үр ашгийг дээшлүүлэх бодлогын хүрээнд "Нэг эх үүсвэрээр худалдан авах" аргын хүрээнд нийлүүлэгдэж байгаа эмийн хангалт хүртээмж хугацаа, хадгалалт, иргэд даатгуулагчдад эмийн талаар мэдээ, мэдээлэлийг хэрхэн хүргэн	100

						ажиллаж буй эсэхэд хяналт тавих зөвлөн туслах ажлыг хийж гүйцэтгэв.	
3.2.3	Гэрээт эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээний нэхэмжлэлд дүн шинжилгээ хийж, шаардлагатай тохиолдолд ЭМД-ын улсын байцаагч (ахлах)-ийн зөвлөмжийг тухай бүр хүргүүлж, биелэлтийг хангуулна	-	Хүргүүлсэн зөвлөмжийн тоо Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь	2024 онд хүргүүлсэн зөвлөмжийн тоо 12, албан шаардлага 1 Хэрэгжилт 92.3 хувь	Тусламж үйлчилгээний чанар хэрхэн сайжирсан талаарх тайланг холбогдох нэгжид хүргүүлсэн байна.	Эрүүл мэндийн байгууллагуудын тусламж үйлчилгээний гүйцэтгэлд нэхэмжлэлийн хяналтыг хэрэгжүүлэн шаардлагатай тохиолдолд улсын байцаагч (ахлах)-ийн зөвлөмжийг тухай бүр хүргүүлэн, биелэлтийг хангуулан, хяналт тавин ажиллаж байна. Энэ онд лавлагаа шатлалын 3 ЭМБ-д 3 удаа, анхан шатны 13 ЭМБ-д 1 удаа Улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлээд байна.	100
3.2.4	Байгууллагын 2023-2026 оны СТ-ний 3.2.3, БГТ-3.2.2 Нэхэмжлэлийн хяналтын үр дүн болон даатгуулагчдын гомдол, саналд үндэслэн эрүүл мэндийн байгууллагуудад газар дээрх хяналт шалгалт хийнэ.	-	Хяналт шалгалтад хамрагдсан байгууллагын тоо -Хяналт шалгалтын тайлан	2024 онд гэрээ бүхий ерхийн эмнэлэг 3, сумын эрүүл мэндийн төв 2 тус тус газар дээрхи хяналт шалгалтыг зохион байгуулсан.	Газар дээрх хяналт, шалгалт хийж, тайланг холбогдох нэгжид хүргүүлсэн байна.	Нэхэмжлэлийн хяналтын үр дүн болон даатгуулагчдаас ирүүлсэн гомдол, санал ирүүлээгүй бөгөөд одоогоор хяналт шалгалт хийгдээгүй болно. 2025 оны сүүлийн хагас жилд хийхээр төлөвлөн ажиллаж байна.	80
4. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилго 4: Эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг төрийн захиргааны нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангана.							
4.1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.1-т заасан "Хүний нөөцийн менежментийг байгууллагын онцлог, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлж, суралцагч байгууллага болон хөгжинө" зорилтын хүрээнд:							

4.1.1	<p>ЗГҮАХ-2.1.9, Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.1.3</p> <p>Ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, Сургалтын хөтөлбөрийн хүрээнд хэлтэс, албан хаагчдад чиглэсэн арга хэмжээг орон нутагтай хамтарч хэрэгжүүлнэ..</p>	ЭМДС	<p>Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, тайлан</p>	<p>Засгийн газрын 2023 оны 272-р тогтоолын дагуу орон нутагт ажилласны нэмэгдлийг үндсэн цалингийн 20 хувиар тооцож 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хэлтсийн нийт ажилтнуудад олгож байна.</p>	<p>Орон нутгийн удирдлагатай хамтран арга хэмжээ авч хэрэгжүүлсэн.</p>	<p>Тус хэлтсийн ажилтнууд Төрийн албан зөвлөлөөс зохион байгуулсан "Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал" зүүн бүсийн зөвлөгөөн, -Төрийн цахим үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, олон нийтийн цахим ур чадварыг нэмэгдүүлэх сургалт зэрэг аймаг орон нутгаас болон бусад төсөл хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан нэгдсэн сургалт зөвлөгөөнд тухай бүр хамрагдаж ажиллав.</p>	100
-------	---	------	--	---	--	---	-----

4.1.2	Салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг сурталчлах, даатгалын орлого хамралтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн нээлттэй өдөрлөг, сургалт, сурталчилгааны бусад арга хэмжээг зохион байгуулна		Зохион байгуулсан арга хэмжээ, сургалтын тоо	Зохион байгуулсан арга хэмжээ-3, сургалтын тоо-10	Сургалт, сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулж, тайлагнасан байна.	Салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг тайлбарлан таниулах зорилгоор - Гэрээ бүхий эрүүл мэндийн байгууллагуудад ЭМДҮЗ-ын тогтоолын шинэчлэлийг цахимаар-3 танхимаар-2 удаа, цаг үеийн холбоотой мэдээлэл /гэрээ хэлцэл, төсвийн хуваарь/ зэргийг цахимаар 2 удаа тус тус зохион байгуулав. Үүнд: анхан шатны 16 байгууллагын 36, лавлагаа шатлалын 2 эрүүл мэндийн байгууллагын нийт 12 эмч, мэргэжилтнүүд хамрагдсан байна. Мөн аймгийн цэрэг татлагын үеэр Хэрлэн сумын 1-11 дүгээр багийн нийгмийн ажилтнуудад шимтгэл төлөлтийн хувь хэмжээ, төлөх заавар, аргачлалын талаар бол мэдээлэл хүргэв. Цаашид төрийн байгууллагын үйл ажиллагааг иргэдэд сурталчлан таниулах, тэдэнд ойртсон төрийн үйлчилгээг хэрэгжүүлэн, төлөвлөх зорилготой "Нээлттэй хаалга"-ны өдөрлөг болон бусад цаг үеийн холбогдолтой төрийн үйлчилгээг иргэн даатгуулагчдад хүргэх, сурталчиллах үйл ажиллагаанд оролцохоор төлөвлөөд байна.	100
-------	---	--	--	---	--	---	-----

4.1.3	Байгууллагын үйл ажиллагааны болон мэдээллийн ил тод байдлыг хангуулах ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, иргэн-даатгуулагчид бодит мэдээ, мэдээлэл хүргэнэ.	-	Иргэд, даатгуулагчдад хүргэсэн мэдээлэл, хандалтын тоо	2024 онд 19224 иргэн, даатгуулагчдад мэдээ, мэдээллийг хүргэсэн.	2025 онд 20000-аас доошгүй иргэн, даатгуулагчдад эрүүл мэндийн даатгалын талаарх мэдлэг, мэдээллийг хүргэсэн байна.	ЭМДЕГ-ын цахим хуудсанд байршсан мэдээ мэдээлэл, контентыг түгээн ажиллаж байна. Хэлтсийн фэйсбүүк хуудсанд нийт 206 мэдээ, мэдээллийг байршуулав. Шинээр дагасан хүний тоо 21, фэйсбүүк хуудсаар 3945 иргэн зочилсон үзүүлэлттэй байна. Бэлтгэсэн контент 35 байна. Иргэд, даатгуулагчдад эрүүл мэндийн даатгалын талаарх мэдээ мэдээллийг хэлтсийн фэйсбүүк хуудас болон нээлттэй утсаар тасралтгүй хүргэсээр байна. Хэлтсийн фэйсбүүк хуудсыг хөгжүүлэхэд анхаарч тайлант хугацаанд: -Мэндчилгээ, -Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиас, -Шимтгэл төлөлтийн хувь хэмжээ, -Шимтгэл төлөх заавар зэргийг байршуулан ажилласан.	100
-------	--	---	--	--	---	---	-----

4.1.4	<p>Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.1.10 Даатгуулагч-иргэд, гэрээт байгууллага, ажилтнуудаас сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг зохион байгуулж, түүний мөрөөр зохих арга хэмжээг авч, нэгдсэн тайланг ерөнхий газарт хүргүүлнэ.</p>		Судалгаанд хамрагдсан иргэдийн тоо	220 иргэнээс сэтгэл ханамжийн судалгаа авсан.	Сэтгэл ханамжийн судалгаа авч, хэрэгжүүлсэн арга хэмжээний нэгдсэн тайланг ерөнхий газарт хүргүүлсэн байна.	<p>Иргэд даатгуулагчдаас авах сэтгэл ханамжийн судалгааг (15 асуумж бүхий) Google form-д байршуулан авлаа. Судалгаанд нийт 157 иргэн хамрагдсан байна. Судалгаанд хамрагдагсдын 138 буюу 88.5 хувь нь эмэгтэй, 31-45 насны иргэд байна. Судалгааны асуумжид хандсан байдлаар ангилбал: Тус байгууллагаас үйлчилгээ авахад хүндрэл байдаг уу? - Үгүй 72.9 хувь Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн албан хаагчдын харилцаа хандлагыг үнэлнэ үү ? - Маш сайн 27.3 - Сайн 38.3 Эрүүл мэндийн даатгалын байгууллагын талаар мэдээлэлтэй байна уу? - Тийм 63 хувь Тус хэлтсийн ажилтнууд танд шаардлагатай мэдээлэл, заавар зөвлөгөө өгч чадсан уу? - Тийм 70.6 хувь Та шаардлагатай эрүүл мэндийн тусламж үйлчилгээгээ Эрүүл мэндийн даатгал ашиглан авч чаддаг уу? - Тийм 60.4 хувь Мөн судалгаанд оролцогчдын 76 хувь нь эрүүл мэндийн даатгалтай холбоотой мэдээллийг Фэйсбүүк хуудсаар дамжуулан авдаг гэжээ. Олон нийттэй харилцах хэлтсээс ирүүлсэн сэтгэл ханамжийн судалгаанд гэрээт эрүүл мэндийн байгууллагыг хамрагдах талаар мэдээлэл өгч ажилласан.</p>	80
-------	---	--	------------------------------------	---	---	--	----

4.1.5	<p>Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.1.15</p> <p>Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд, үнэн зөв шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, шийдвэрлэлтэд хяналт тавьж тайлагнана.</p>	-	<p>Албан бичиг, өргөдөл, гомдлын тоо, шийдвэрлэлтийн хувь</p>	<p>Албан бичиг, өргөдөл, гомдлын тоо 750, шийдвэрлэлт 100 хувь.</p>	<p>Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг хагас, бүтэн жилээр нэгтгэн тайланг ерөнхий газарт хүргүүлсэн байна.</p>	<p>Тайлагналын хугацаанд тус хэлтэст бүртгэж хүлээн авсан албан бичиг-37, төлөвлөж хүргүүлсэн-64, Ирсэн дотоод бичиг- 17, Явсан дотоод бичиг- 11</p> <p>Иргэдээс ирсэн гомдол, санал хүсэлт -701 тус тус бүртгэгдсэн байна. Үүнээс -35 нь хариутай албан бичиг байна.</p> <p>Хугацаа хоцорч шийдвэрлэсэн албан бичиг, өргөдөл гомдол байхгүй болно. Санал хүсэлт, өргөдөл гомдлыг хандсан хэлбэрээр нь ангилвал</p> <ul style="list-style-type: none"> - Цахимаар-38 - Лавлах утсанд хандсан-150 - Биечлэн ирсэн-513 - Олон нийттэй харилцах 1111 төвд хандсан-0 байна. <p>Өргөдөл гомдол, санал хүсэлтийг агуулгаар нь ангилвал:</p> <ul style="list-style-type: none"> - шимтгэл төлөлттэй холбоотой асуудлаар-579 - Тусламж үйлчилгээтэй холбоотой асуудлаар-32 - Төрсөн эх, халамжийн тэтгэвэр авагч төр хариуцах бүртгэл ногдуулалт-33 - Шинээр төрсөн хүүхдийн бүртгэл үүсгэх-35 - Эмийн үнийн хөнгөлөлттэй холбоотой-2 - Хурууны хээтэй холбоотой-2 - Бусад-18 хандсан байна. <p>Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээг нэгтгэн хүргүүлсэн.</p>	100
-------	---	---	---	---	---	--	-----

4.1.6	Даргын зөвлөлийн болон шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангаж ажиллана.	-	Өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь	ЭМДЕГ-ын удирдлагуудын шуурхайгаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг 17 удаа гаргаж хэрэгжилт 100 хувь.	Удирдах дээд газраас өгөгдсөн үүрэг даалгаврыг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.	Долоо хоног бүрийн Мягмар гаригт зохион байгуулагддаг ЭМДЕГ-ын удирдлагуудын шуурхай хуралдаанд тогтмол хамрагдаж байна. Шуурхайн хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг ханган ажиллаж, мэдээг тайланг нийт 6 удаа гаргаж хүргүүлэв.	100
4.1.7	Цаг үеийн шинжтэй удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгавар болон хэлтсийн дотооддоо хийж гүйцэтгэсэн ажлуудын хэрэгжилтийг хангаж биелэлтийг хугацаанд нь үнэн зөв тайлагнана.	-	Үүрэг даалгаврын тоо, хэрэгжилтийн хувь	-	Үүрэг даалгаврыг биелэлтийг хугацаанд нь хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажилласан байна.	Долоо хоног бүрийн Даваа гарагт зохион байгуулагддаг аймгийн удирдах ажилтны шуурхай хуралд тогтмол хамрагдаж байна. Аймгийн ЗДТГ-ын холбогдох газар хэлтсүүдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу тайлант хугацаанд дараах судалгааг гарган хүргүүлэхийн зэрэгцээ цаг үеийн холбогдолтой хурал, зөвлөгөөнд тогтмол хамрагдаж байна. Үүнд: - Төрийн байгууллагуудын албан хаагчдын 2025 оны сугалтын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох судалгаа, - Цахимаар үзүүлж буй тусламж үйлчилгээний талаарх судалгаа, - Аймгийн Прокурорын газарт Улсын байцаагч, эрх бүхий албан тушаалтны мэдээлэл судалгааг тус тус гарган хүргүүлсэн.	100

4.1.8	Нэгжийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилт, цаг бүртгэлд хяналт тавих, ажил үүргийг тэнцвэртэй, оновчтой хуваарилах, зөвлөн туслах, чиглүүлэх, өдөр тутмын удирдлагаар хангах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	-	Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөө, ГТ-ний биелэлтийн хувь	Хэлтсийн мэргэжилтэнтэй гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгуулж, гүйцэтгэлийг хагас болон бүтэн жилээр дүгнэж, ЭМДЕГ-т хүргүүлэн ажилласан байна.	Гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, ажлын гүйцэтгэл, үр дүнг хагас, бүтэн жилээр үнэлж, дүгнэсэн байна	Тус хэлтсийн ажилтан албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлан, ажлын цаг ашиглалт, ажил үүргийн тэнцвэртэй байдлыг харгалзан, ажлыг оновчтой хувиарлан өдөр тутмын удирдлагаар ханган ажиллаж байна.	100
4.1.9	Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг стандарт, зааврын дагуу явуулж, архивын нэгж бүрдүүлэх ажлыг зохион байгуулна.	-	Архивын нэгжийн тоо (боть)	2023-2024 оны 57 архивын нэгжийг бүрдүүлж, албан бичиг хөтлөлийн анхан шатны баримтуудыг цэгцлэн ЭМДЕГ-ийн архивт хүлээлгэн өгөхөөр бэлтгэсэн.	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу архивын нэгжийг бүрдүүлсэн байна.	Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж, ЭМДЕГ-ын даргын Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хадгаламжийн нэгж бүрдүүлэн ажиллаж байна. 2024 онд нийт 29 архивын нэгж баримтыг эмхлэн цэгцэлж үдсэн, 2025 оны баримтыг тухай бүрт цэгцэлж эмхэлж байна.	100

4.1.1 0	Монгол хэлний тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 7.2 дахь хэсгийг дагаж мөрдөн, 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөн явуулна.	-	Хос бичгээр хөтлөн гаргасан албан бичгийн тоо, -Хэрэгжилтийн хувь	-	Албан хэрэг хөтлөлтийг үе шаттай хэрэгжүүлж, зохих бэлтгэл хангасны үндсэн дээр албан хэргээ кирил болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулна.	Тус хэлтэс нь төрийн байгууллагын албан хэргийн үйл ажиллагааг хос бичгээр явуулахад шаардлагатай албан бланк зэргийг АБЛЕ системд суулгаж бэлтгэлийг ханган ажиллаж байгаа бөгөөд одоогоор хос бичгээр хөтлөн явуулж эхлээгүй байна.	100
4.1.1 1	Цахим гарын үсгийг байгууллагын үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлнэ.	-	Цахим гарын үсгээр албажсан албан бичгийн тоо	-	Цаасан хэлбэрт байгаа мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлэх, илгээх, хүлээн авах, хадгалах үйл ажиллагаан д цахим гарын үсэг нэвтрүүлсэн байна.	Тус хэлтсийн албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг стандартын дагуу хөтлөн явуулахын зэрэгцээ албан бичиг илгээх, шилжүүлэх, хадгалах, хүлээн авах, төлөвлөх үйл ажиллагааг цаасан хэлбэрээс цахим хэлбэрт шилжүүлж тоон гарын үсгээр баталгаажуулан ажиллаж байна. Төлөвлөж хүргүүлсэн албан бичиг 64, үүнээс цахим гарын үсгээр баталгаажуулсан 5 байна.	100
4.1.1 2	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллана	-	Хэрэгжилтийн хувь	Хуулийн хугацаанд ХАСХОМ, ХАСУМ-ээ 100 хувь мэдүүлсэн байна.	Хэрэгжилтийг ханган ажилласан байна.	Тус хэлтсийн ажилтан, албан хаагчид ХАСХОМ, ХАСУМ-ээ хуулийн хугацаанд бүрэн мэдүүлсэн.	100
5. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх зорилтын хүрээнд							


5.1	Агентлаг болон бусад байгууллага, төсөл хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдах арга зүйн сургалт, семинарт бүрэн оролцоно.	-	Хамрагдсан сургалтын тоо	-	Сургалтад бүрэн хамрагдсан байна.	Цахим хөгжил, инноваци, харилцаа холбооны яам, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, Дорнод аймгийн цахим үйлчилгээний хэлтсээс зохион байгуулсан - "Төрийн цахим үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, олон нийтийн цахим ур чадварыг нэмэгдүүлэх DEMOSC" төслийн талаар сургалт, - Аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын систем ERP E-Mongolia, DocX системийн талаар сургалт, - Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан "Мэдүүлэг гаргагч мэдүүлгээ хэрхэн бөглөх чиглүүлэх цахим сургалт, - ЭМЯ Хөгжлийн төвөөс "6 насны эрт илрүүлэг үзлэг" талаар сургалтад 4 удаа -Татварын газраас зохион байгуулсан "Татварын ач тус" сэдэвт сургалт зэрэгт тус тус хамрагдсан байна.	100
-----	---	---	--------------------------	---	-----------------------------------	---	-----

5.2	<p>Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.1.4 ЭМДЕГ-аас баталсан сургалтын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах сургалтад тогтмол хамрагдана.</p>	-	Хамрагдсан сургалтын тоо	ЭМДЕГ-аас зохион байгуулсан сургалтад тогтмол хамрагдсан.	ЭМДЕГ-аас баталсан сургалтын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах нийт сургалтад бүрэн хамрагдаж мэдлэг, мэдээлэл авсан байна.	<p>ЭМДЕГ-аас баталсан сургалтын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан сургалтад тухай бүр тогтмол хамрагдлаа.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> -Тамгын газрын “Мэдээллийн цаг” хөтөлбөр 5 - Бодлого төлөвлөлтийн газрын ЭМДҮЗ-ийн шинэчилсэн тогтоолын төсөл танилцуулах сургалт 3, - 6 настны эрт илрүүлэг үзлэгийн талаар мэдээлэл сургалт 1, - Худалдан авалт гэрээлэлтийн газрын 2025 оны гэрээ, хэлцэл, төсвийн хуваарын талаарх мэдээлэл сургалт 4, - ЭМДЕГ-ын холбогдох газар хэлтсүүдээс зохион байгуулсан 4, <p>Нийт 17 удаагийн сургалтанд хамрагдсан байна.</p>	100
5.3	<p>Төрийн албан хаагчийн ёс зүй, удирдлагын манлайлал, хувь хүний хөгжлийн чиглэлээр танхимын болон онлайн сургалтуудад хамрагдаж, мэдлэг, ур чадвараа дээшлүүлнэ.</p>	-	Хамрагдсан сургалтын тоо	Нийт 30 удаагийн сургалтад оролцсон.	Сургалт, семинарт бүрэн хамрагдсан байна.	<p>Тус хэлтсийн ажилтнууд 2025 оны 5 дугаар сард Хэнтий аймгийн Чингис хотод зохион байгуулагдсан “Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал” Зүүн бүсийн зөвлөгөөнд оролцлоо. Тус зөвлөгөөнөөр төрийн албаны шинэтгэл, үр дүн, төрийн албан хаагчийн ёс зүй, манлайлал, орон нутаг дахь төрийн албаны шинэтгэл-сорилт-шийдэл зэрэг сэдвүүдээр илтгэл хэлэлцүүлгийг өрнүүлсэн зөвлөгөөн боллоо.</p>	100

5.4	Монгол бичгийн мэдлэг, чадварын түвшинг ахиулах сургалтад хамрагдах	-	Хамрагдсан сургалтын тоо	-	Албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг, чадвар дээшилж, Монгол бичгийн хэрэглээний орчин сайжирсан байна.	Тус хэлтсийн албан хаагчид Монгол бичгээ сурч эзэмших, судлах, мэдлэгээ дээшлүүлэхэд анхаарч бие даан унших, бичих байдлаар бичгийн мэдлэг, чадварын түвшинг ахиулахад анхааран ажиллаж байна.	100
-----	---	---	--------------------------	---	---	--	-----

Төлөвлөгөөг үнэлсэн

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА



Төсвийн шууд захирагч

/ С.ЭНХБОЛД /

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ
ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА



Нэгжийн дарга

/ Б.ОЮУНЦЭЦЭГ /
2021.06.04

Тайлагнасан:

ДОРНОД АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



/ Ш.ЭНХМАА /